Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

22 дахь жилдээ № 89 (1873) | 1969 оны 11 дүгээр сарын 27 | ПҮРЭВ

## СҮЛД МОДНЫ НААДМАА ХИЙВ

Баяндэлгэр сумын үйлдвэрийн хоршооллын артелийн хамт олон 1969 оны жилийн төлөвлөгөөгөө 2 сарын өмнө 125 хувиар биелүүлэн шинэ жилийнхээ сүлд модны наадмаа саяхан хийж 1970 оныхоо ажилд оров

**Х. Түвдэн**

### *ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА*

Аймгийн эрчим хүчний салбарт 1970 оны тогтмол хэвлэл захиалга амжилттай явагдаж байна.

Салбарын хэмжээгээр 16 төрлийн 675 төгрөгийн хэвлэл захиалсны дотор мастер Намхай, монтёр Даваасодном, байцаагч Дэлгэртогтох нарын олон хүн идэвхтэй оролцлоо.

**Д. Дамдин**

# Мал тооллого

Мал аж ахуйн тооллогыг үнэн зөв явуулах нь манай аймгийн ард түмнээс 1969 онд мал аж ахуйгаа хөгжүүлэх талаар ямар амжилт олсныг дүгнээд зогсохгүй, дараа жилийн зорилтыг тодорхойлж, үүлдэр угсааг сайжруулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэл бэлтгэлийн төлөвлөгөөг улам нарийсган боловсруулж хуваарилахад үндсэн материал болох улс төр, эдийн засгийн үлэмж ач холбогдолтой чухал компанит ажил юм. Өнгөрсөн жилүүдийн байдлаас үзэхэд манай орон нутгийн нам, улс, аж ахуйн зарим байгууллагаас мал тооллогын ажилд хайнга хандаж, удирдан зохион байгуулах ажлыг сулруулан, бэлтгэлийг сайн хангахгүй явуулснаас болж бүх малыг толгой дараалан тоолохгүй орхигдуулах, нас хүйс, үүлдэр угсааг буруу бүртгэх явдал гарч, мал тооллогын заавар зөрчиж байсны дээр алдаж үхүүлсэн малаа бэлэн байгаад тоолуулах, эсвэл идэшинд хэрэглэх малаа тоолуулахгүй өнгөрөөх, зориуд нууж дарах зэрэг дутагдал Заамар, Алтанбулаг сумдад үзэгдэж байлаа. Энэ бүх байдалд манай нам, улс, аж ахуйн байгууллагууд дүгнэлт хийж, одоо болох гэж байгаа мал тооллогын ажлын бэлтгэлийг сайн хангаж, маш хариуцлагатай зохион байгуулан үнэн зөв явуулахад бүхий л идэвх чармайлтаа дайчлан ажиллах нь чухал байна.

Энэ тооллогоор сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдэл зэрэг улс, хоршооллын байгууллагын бүх мал, ажилчин албан хаагчид, ХАА-н нэгдлийн гишүүдийн амины мал сүргээс гадна хөдөө аж ахуйн бусад тэжээвэр амьтад гахай, шувуу зэргийг нас хүйс, үүлдэр угсаагаар нь ялгаварлан толгой дараалан бичилж тоолохын хамт хашаа худгийг хэмжиж тоолно.

Мал тооллогыг үнэн зөв явуулахын тулд сум — нэгдэл, СAA-н өрх, хүн ам, малын хөдөлгөөний орлого, зарлагын тооцоог урьдчилан гаргасан байх ёстой.

Мал аж ахуй бүхий бүх байгууллага болон иргэд хоорондоо шилжүүлэх, худалдах, нийгэмчлэх зэрэг мал сүргийнхээ бүх хөдөлгөөнийг 12 дугаар сарын 5-ны дотор хийж дуусгасан байх хэрэгтэй. Хэрэв заасан хугацаанд дээр дурьдсан хөдөлгөөнийг урьдчилан хийгээгүйгээс тооллогын ажлыг хүндрүүлэхэд хүргэвэл уул малыг хариуцагч хүний нэр дээр нь тоолвол зохино.

Үүний хамт мал тооллогын комиссын бүрэлдэхүүнийг хамгийн дадлага, чадвартай хүмүүсээр тавьж, тэднийг семинар заавраар сайн хангаж тооллогоос нэг ч мал үлдээхгүйн тулд тусгай эрлийн бригад, комиссыг байгуулан гаргаж эзэнгүй яваа малыг цуглуулж, эздийг нь олгож өгөх ба эзэнгүй малыг тусгайлан бүртгэвэл зохино. Мөн айл өрх бүрт хэдийд тоолохыг урьдчилан зарлаж, уг өдөр малаа бэлэн байлгуулах арга хэмжээг авахын гадна тооллогыг хугацаанд нь дуусгахын тулд тоологч комиссын хүчийг хэдэн хэсэг болгон хуваарилаж зэрэгцүүлэн тоолохын хамт хяналтын тоологч нарыг ажиллуулах нь зүйтэй.

Тоолох нутаг дэвсгэрийн хил хязгаарыг хатуу тогтоон, тооллогын үеэр хилийн заагийн харуул манааг ажиллуулж мал тооллогын ажлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 385 дугаар тогтоол ёсоор 12 дугаар сарын 10-16-ны дотор дуусгах хэрэгтэй.

ГАВШГАЙЧДЫН ЗӨВЛӨЛГӨӨНД ОРОЛЦОГЧДОД БАЯР ХҮРГЭЕ!



МАНАЙ АЙМГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД

## *ӨРМИЙН МАСТЕР*

Геологи хайгуулын өрмийн мастер Дорж геологи хайгуулын ажлыг 11 жил тасралтгүй хийсний дотор өрмийн ээлжийн мастераар 9 жил ажиллахдаа төлөвлөгөөг 125-аас дээш хувиар биелүүлж ирлээ.

Дорж нь ЗПК—30 маркийн өрөмдөгч машиныг хүлээж авсанаасаа хойш их засвар хийлгүйгээр ажиллаж байна.

Ажилд гарахаас 30 минутын өмнө ирж техникийн тохируулга хийж, эрэг боолтны чанга сулыг шалгаж зассаны дараа арчиж цэвэрлээд тосолгоо үйлчилгээг тогтмол хийж ажилд ороход бэлэн болгодог учраас ажил эхлэснээс хойш техникийн саатал гардаггүй байна.

Өрөмдөгчийн мэргэжилд 15 хүнийг дагалдуулан сургасны гадна одоо нэг ажилчныг өрмийн мастерийн мэргэжилтэй болгохоор ажиллаж байна.

Техникээ хайр гамтай эдлэж өдөр тутам арчлан тордож ажилладаг учраас 1967—1968 оны өрмийн төлөвлөгөөг 267 хувь, 1969 оны 10 сарын төлөвлөгөөг 268 хувиар биелүүлээд байна.

Үйлдвэрийн дотоод нөөц бололцоог бүрэн дүүрэн ашиглах зорилгоор хаягдал клонковая труб,коронка, шломын яндангуудыг засч сэлбэж ашигласнаар улсад 2 мянга шахам төгрөгийн цэвэр ашгийг оруулсан байна.

**С.Сорогдорж**

## ЦОЛ МАНДАТ ГАРДУУЛАВ

Төвийн артелийн Жамсран ахлагчтай СХТ хивсэн тасагт СХ-ийн тасгийн цол, мандат гардуулах хурал Соёлын ордонд боллоо. Жамсран ахлагчтай СХ-ийн хивсэн тасагт олгох цол мандатыг аймгийн АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны дарга Ц. Жамсран гардуулав. Хурал дээр аймгийн Намын Хороо, АДХ-ын Гүйцэтгэх Захиргааны баярын бичгийг СХ-ийн хивсэн тасгийн ахлагч Жамсранд гардуулан өгөв. Тус хурал дээр МҮХ-ын Төв Зөвлөл, Аймгийн үйлдвэрийн хоршооллын холбоо болон аймгийн үйлдвэр,албан газар олон нийтийн байгууллагын баярын бичиг, дурсгалын зүйлийг гардуулсан байна. СХ-ийн хивсэн тасгийн хамт олноос их ойнууд угтаж дэвшилтэд үүрэг авав.

**Манай сурвалжлагч**

## Идэвхтний мэдээ

## *БАЯРЫН ХУРАЛ*

БНМАУ—ыг тунхагласны 45 жилийн ойд зориулсан аймгийн Намын Хороо, АДХГ Захиргаа, Зуунмод хотын нам, улс, олон нийтийн байгууллага, хөдөлмөрчдийн баярын хурал болов.

Баярын хуралд „БНМАУ-ыг тунхагласны 45 жилийн ой" гэсэн илтгэлийг аймгийн АДХГ Захиргааны дарга Ц. Жамсран тавив.

Хурлын дараа «Ардын элч» гэдэг уран сайхны кино гарав.

**Ш. Цэрэндоо**

## ШЕФИЙН ТОГЛОЛТ

Заамар нэгдлийн шеф Дуурь бүжгийн улсын театрын хэсэг жүжигчид тус суманд ирж, нэгдлийн тайлан сонгуулийн хурлаар тоглолт хийлээ.

БНМАУ—ын гавъяат жүжигчин Норовбанзадын дуулсан «Зээргэнтийн шил», «Уяхан замба тив», дуучин Лхамжав, Гэрэлтод, Банзрагч нарын дуулсан дуунууд, мөн Дэлхийн залуучууд оюутны алтан медальт бүжигчин Намжилын бүжиглэл, мөнгөн медальт Мэнд-амарын хөгжимдөлт нэгдэлч олны сонирхлыг ихэд татав.

**Б. Сандаг**

## ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭВ

Баяндэлгэр сум—нэгдлийн кино салбар кино гаргалтын жилийн төлөвлөгөөг 105 хувь, үзэгчдийн төлөвлөгөөг 104 хувь, орлогын төлөвлөгөөг 152,4 хувиар биелүүлэв.

**Б.Доржсүрэн**

## *ШИНЭ КОНЦЕРТ*

Аймгийн Соёлын ордон их ойнуудыг угтаж шинэ концерт бэлтгэж тоглолоо. Хөгжмийн зохиолч Батсүхийн бичиж найруулсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн чуулга, ардын дуу Юндэн—гөөгөө, Ширээнуур дуугаар дан найраг найруулан тоглосон нь үзэгчдийн сонирхлыг ихэд татлаа.

Мөн Бурнад АССР-ийн зохиолч Томунко-Пурвуевийн зохиол «Хүргэн хүү» гэдэг жүжгийг найруулагч Болд орчуулан найруулж аймгийн Соёлын ордны тайзан дээр анх удаа тоглосон нь их амжилттай боллоо.

Уг жүжгийн гол дүрд тоглосон жүжигчин Нямсүрэн, Нэргүй, Эрдэнэчулуун, Уртнасан, Сэрээтэр нар үзэгчдээс өндөр үнэлэлт авлаа.

**Х. Цэрэнжав**

